

## **ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ДУГААР САРЫН МЭДЭЭ**

### **Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, “Монгол цахим засаглал” хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн “Хариуцлагатай засаглал-Хамтын оролцоо” хүрээнд “Шинэ-Мөрөн” худалдаа үйлчилгээний төвд иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ” байгуулагдлаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, орон нутагт зохион байгуулах салбар комиссыг аймгийн Засаг даргын 2019 оны А/201 дүгээр захирамжаар томилж, үзлэгт хамрагдах байгууллагуудын нэрсийг батлан үзлэг явуулах хуваарийн дагуу салбар комиссын үзлэгийг 5 дугаар сарын 20-иос эхлэн нийт 22 сумын ЗДТГ, 1 тосгоны захирагчийн ажлын алба, 39 байгууллагад үзлэгийг зохион байгууллаа.

Японы Жайка олон улсын байгууллагаас “ Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллыг сайжруулах” төслийг Хөвсгөл аймагт 2016 -2019 оны хооронд хэрэгжүүлж төслийн хаалтын арга хэмжээ зохион байгуулагдлаа. Тус төсөл нь улсын хэмжээнд Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, Хөвсгөл аймагт хэрэгжсэн нь манай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлж эрт илрүүлэх, эдгээр хүүхэдтэй ажиллах төрийн болон төрийн бус байгууллагын боловсон хүчнийг чадваржуулахад ихээхэн хувь нэмэр орууллаа.

2019.05.16-26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Тэжон хотын харилцаа, хамтын ажиллагаат Со дүүрэгт Хөвсгөл аймгийн эмч нарын баг Илжи их сургуулийн эмнэлэгт эх барих эмэгтэйчүүд, гэмтлийн мэс засал, зүрх судас, зүрхний эхо чиглэлээр 10 хоногийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдлаа.

2019.05.23-28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Тэжон хотын харилцаа, хамтын ажиллагаат Со дүүрэгт жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг урлагийн “Healing Art” фестивалд Хөвсгөл аймгийн төрийн алба, урлаг, аялал жуулчлалын салбарын төлөөлөл амжилттай оролцлоо.

Хөвсгөл нуурын эрэгт байрлах ахмадын “Эрчим-2” амралт сувиллын газар нээлтээ хийлээ. Нэг ээлжид 75-80 амрагч хүлээн авах хүчин чадалтай нуурын баруун эрэгт цэвэр агаартай байгалийн үзэсгэлэн цогцолсон газар ахмад настнуудад зориулсан эмчилгээ, сувилгаа, бариа засал хосолсон үйлчилгээ сайтай амралт нээгдсэнд амрагчид төдийгүй нийт ахмадууд сэтгэл хангалуун байлаа.

### **Хоёр. Эдийн засаг,төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

"Банкны хөгжил 95 жил" аяны хүрээнд Хөвсгөл аймгийн банкны салбарын нээлттэй хаалганы өдрийг Монголбанк, Хаан банк, Төрийн банк, Голомт банк, Хас банк хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээний зорилго нь Монгол улсын банкны салбарын үүсэл хөгжил, улс орны нийгэм эдийн засагт гүйцэтгэсэн үүрэг, арилжааны банкуудын үзүүлж буй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, түүний хүртээмж ач холбогдлын талаар олон нийтэд таниулахад чиглэгдсэн байна.

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2019 оны 4-р сард 46 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 15,4 тэрбум төгрөгний 2,632 ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 4-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 1,998,2 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 2,760,0 сая төгрөг буюу 138,1% хувийн гүйцэтгэлтэйгээр давуулан биелүүсэн байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 33,107.7 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 18,909.4 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 12,065.2 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 100,409.6 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 1,405.4 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 33,107.7 сая төгрөг, Зарлагын гүйцэтгэл 30,025.8 мянган төгрөг буюу 90.7% хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна..

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага 1,109.1 сая төгрөг өмнөх сараас 408.4 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт өглөг 1,339.9 сая төгрөг өмнөх сараас 165.0 сая төгрөг өссөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлан Төрийн аудитаар орж хуулийн хугацаандаа “Зөрчилгүй” дүгнэлтийг авч Сангийн яамны Төв Төрийн сангийн газарт нэгтгүүлж байна.

Аймгийн 2018 оны давсан орлого, дансны үлдэгдлийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.04.03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталж нэн тэргүүнд шаардлагатай арга хэмжээ, хөтөлбөр төслүүдэд хуваарилагдсан байна.

2019 оны 05 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 1653,2 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 144,5 сая төгрөгийн , шимтгэлийн орлого 114,9 % -аар биелсэн байна

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Татвар төлөгчдийн өдрүүд-2019” арга хэмжээний хүрээнд Татварын байгууллагын зүгээс татвар төлөгчдөө өнгөрсөн жилийн ажлын амжилтаар нь урамшуулан шагнах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд гар зураг, эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулах, тэдэнд татвар төлөгч үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн танилцуулга аяллыг зохион

байгуулах, Аж ахуй нэгж байгууллага, иргэн, Төрийн болон төрийн бус байгууллагуудад татварын хуулийн өөрчлөлт, шинэчлэлт, системийн талаар сургалт сурталчилгааг хийх зэрэг ажлуудыг чанартай хүртээмжтэй зохион байгуулсан өдрүүд болж өнгөрлөө.

### **Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд**

Архивын улсын үзлэгтэй холбогдуулан сум, агентлаг, төрийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг хамруулан сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Уг сургалтанд 23 сум, 1 тосгон болон 71 агентлаг, байгууллагын 100 гаруй албан хаагчид оролцсон байна.

2019 оны 05 сарын байдлаар гэмт хэрэг өмнө оны мөн үеэс 47 буюу 12,8 %-аар буурсан дүнтэй. Захиргааны зөрчил өмнө оны мөн үеэтэй харьцуулахад 2064 буюу 34,8 %-аар өссөн. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 14 буюу 70%, хулгайн гэмт хэрэг 70 буюу 44,3 %-аар буурсан байна.

“Эх үрсийн баяр” –ыг угтан хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор 128 хүнсний үйлдвэр, цех, нийтийн хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтын явцад хадгалалтын хугацаа дууссан 317 нэрийн 2.336.200 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч устгалын комисст шилжүүлж, 21 газарт зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-аас “Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сарын аяны хүрээнд Онцгой байдлын газар, Тагнуулын хэлтсийн бүрэлдэхүүнтэй хамтран Могойн гол ХК-ний тэсрэх материалын агуулахад үзлэг тооллого хийж, тэсрэх материалыг нэр төрөл тус бүрээр нь тоолж акт, үйлдэж гарын үсэг зурж баримтжуулсан.

Аймгийн Засаг даргын А/119 тоот захирамжаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж 12 зөрчил илрүүлж, 4 зөрчилд 139,0 сая төгрөгний акт тогтоож, бусад зөрчилд хугацаатай албан шаардлага өгч ажиллалаа.

Хөвсгөл аймагт барилгын угсралтын үйл ажиллагаа явуулж байгаа 8 компаний ажлын чанар байдалд хяналт шалгалт хийж барилгын бат бөх байдал, барилгын ажилтай холбогдох бичиг баримтын бүрдүүлэлттэй холбоотой шаардлага хангахгүй дутагдлуудыг илрүүлж, илэрсэн зөрчлийн 40 гаруй хувийг газар дээр нь арилгуулсан.

Мөрөн сумын 7 захаас хөрсний дээжийг хог хаягдлын цэг болон нүхэн жорлонгийн ойролцоох цэгээс авч нян судлалын лабораторид шинжлүүлэхэд хөрсний бохирдол өндөр гарсан тул ариутгал халдваргүйтгэл хийх тусгай зөвшөөрөлтэй Ган-Өрлөг ХХК-ны удирдлагатай уузалт хийж санал солилцон, бохирдолтой захуудтай халдваргүйжүүлэлт, ахуйн шавьж, мэрэгч устгалын гэрээ байгуулж, хөрсний халдваргүйтгэлийн үйл ажиллагааг тогтмол явуулахыг зөвлөлөө.

### **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

Аймгийн Боловсрол соёл урлагийн газар, Аймгийн Нийтийн номын сангийн хамт олонтой хамтран аймгийн хурдан уншлагын уралдааныг зохион байгууллаа. Аймгийн төвийн 9 сургуулийн 18 сурагчийг БСУГ-т, 14 цагт 23 сумын сурагчдаас Zoom программ ашиглан хурдан уншлагыг цахим хэлбэрээр явуулж дүнг нэгтгэн гаргалаа.

Аймгийн БСУГ, Дэлхийн зөн ОУБ, Нийтийн номын сантай хамтран Номын санч нарын нэгдсэн сургалтыг 2 дахь жилдээ хамтран зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтад Сургууль, соёлын төвийн нийт 66 номын санч нар хамрагдлаа. Дэлхийн зөн ОНХ-ийн хамт олон үйл ажиллагааг дэмжиж “Бид ном унших дуртай” номын клубуудыг дэмжих аяны хүрээнд Номын клубуудын сурагчдын үзэсгэлэнг хамтран зохион байгууллаа.

Аймгийн засаг даргын Хөгжлийн хөтөч хөтөлбөрийн “Өв соёл-Эрч хүч” дэд хөтөлбөрийн хүрээнд Аймгийн БСУГ, Аймгийн Зураач урчуудын холбоо, Хатгал тосгоны соёлын төвтэй хамтран Соёл бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, аялал жуулчлалын бренд бүтээгдхүүн үйлчилгээг бий болгох үүднээс Хатгал тосгонд Уран зургийн үзэсгэлэн, бэлэг дурсгалын дэлгүүр нээлээ. Энэхүү арга хэмжээний үеэр Хатгал тосгоны Орон нутаг судлах танхим үүд хаалгаа нээж гадна дотны жуулчдыг хүлээн авах орчинг бүрдүүлж чадлаа.

Улаанбурхан,улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтад хамрагдвал зохих 18601 хүүхдийн 18228 буюу 97% нь хамрагдсан байна.

УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалангийн санаачлагаар Эрүүл мэндийн байгууллагуудын хүүхэд,мэс заслын эмч сувилагч нарт "Хүүхдийн мэс заслын өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээ"сэдэвт сургалтыг ЭМГ-тай хамтран зохион байгуулж нийт 100 эмч,мэргэжилтнүүд хамрагдаж шинэ мэдлэг мэдээлэл олж авлаа. Мөн энэ үеэр 13 хүүхдэд мэс заслыг үнэ төлбөргүй хийлээ.

Аймгийн хэмжээнд Олон улсын сувилагчдын өдрийг угтан олон талт үйл ажиллагааг ЭМБ-ууд санаачлан зохион байгуулж 830 сувилагч тусгай мэргэжилтнүүд 17892 иргэдэд сувилахуйн тусламж үйлчилгээг иргэдэд үзүүллээ.

#### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:**

5 дугаар сарын дунд үеэр Хатгал тосгон, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Арбулаг, Цэцэрлэг суманд ихээхэн хэмжээний хур тунадас, нойтон цас орж, цасан шуурга шуурч Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгонд 9000 гаруй мал зогсоогоор өлдсөн байдалтай байсан. Аймгийн онцгой байдлын комисс хуралдаж, ажлын хэсэг Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгонд ажиллан малчдад өвс тэжээлийн тусламж үзүүллээ.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар аймгийн зооноз өвчин судлалын төвтэй хамтран Цагаан-Уул сумын иргэдэд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх 1 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Мөрөн сумын томоохон зах худалдааны төвүүдэд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас байршуулж, иргэдэд зурагт хуудас тарааж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр тарвага агнахгүй байх, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сэрэмжүүлэг мэдээг өгсөн.

## **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

Аймгийн засаг даргын А/180 захирамжаар Мөрөн сумын нутаг дэвсгэр дэх инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, бүст хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулах санал дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Хатгал сумын захирагчийн албаны барилгын барилга угсралтын ажил болон Мөрөн сумын 17, 18 дугаар байрны дээврийн засварын ажил, хуучин орон сууцны байруудын гадна фасадын ажил, 4-р багт Гэрлэн дохионы ажил, 50/100 цогцолборын зам засвар зэрэг ажлууд явагдаж байгаа ба Мөрөн сумын 17, 18 дугаар байруудын дээврийн засварын ажил дуусч ашиглалтад хүлээн авлаа.

Үндэсний аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх хэмжээний хүрээнд иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр үйл ажиллагаа нь газрын тухай хуулийн дагуу 24 сумын 2015-2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, тухайн онуудын Засаг даргын захирамжид нийцлийн аудит хийж эхлүүлээд байна.

Мөрөн сумын 31 усан сан, 16 гүний худаг, ЦУШС, усны эх үүсвэйн 1,2,3 дугаар худагас дээж авч лабораторит хими, нян судлалын шинжилгээнд хамруулж дүгнэлт гаргууллаа. Нэрлэсэн жилийн Хөвсгөл Ус суваг ХХК хүүхдийн “Урандөш” зусланд халуун усны барилгын засварыг өөрсдийн хөрөнгөөр хийж тохижууллаа.

### **Долоо. Сум, орон нутгийн талаар**

Бүрэнтогтох сум “УРЛАГ СПОРТЫН БАГА НААДАМ”-ыг зохион байгуулж, сумын бүх байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагчид, 6 багийн иргэд нийт 323 иргэн оролцсон байна. Мөн “Ногоон сум-Бүрэнтогтох” аяныг зохион байгуулж, 4 нэр төрлийн 2500 ширхэг модыг иргэд, албан хаагчдын оролцоотойгоор тарьж томоохон бүтээн байгуулалтын ажлыг зохион байгууллаа.

Эрдэнэбулган сумын газар тариалан эрхлэгч ААН-үүд хаврын тариалалтаа хийж дуусгалаа. 05-р сард 3484 га-д улаан буудай, 60 га-д арвай, 50 га-д рапс, 10 га-д ногоон тэжээл тариалсан бол 16 га-д төмс, 9 га-д хүнсний ногоо тариалсан байна.

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчдын хандивын хөрөнгө 9 сая төгрөгөөр хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талбайг өөрсдийн хүчээр хийж сургуулийнхаа хуучин модон хашилтыг буулгаж, шинэ хашилт хийж, орчныг тохижуулсан байна.

Түнэл суманд “Олон улсын гэр бүлийн өдөр” –өөр “Аз жаргалтай гэр бүл” сэдвийн хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд эссэ бичлэг, гар зургийн уралдаан, “Эгийн солонго” хүүхдийн цэцэрлэгийн эцэг, эх, хүүхдийн дунд “Бидний урлан” багийн тэмцээн амжилттай зохион байгууллаа.

Ренчинлхүмбэ суманд “Шишгэд хурд-2019” хойд бүсийн хурдан морьдын хаврын уралдаан зохион байгуулж 13 сумын 297 морьт 6 насанд уралдлаа. Мөн Зорилтот бүлгийн

өрхийн дуу хоолойг сонсох өдөр зохион байгуулж хүүхдийн тулгамдаж буй асуудлуудыг холбогдох байгууллагууд шийдвэрлэн ажиллалаа. Мөн эцэг эхийн чуулганыг зохион байгуулж 150 эцэг эхийг оролцууллаа.

Их-Уул суманд Буянтай аав ээж” арга хэмжээний шагнал гардуулах арга хэмжээ, ЕБС-ийн ажилчдын “Монгол бахархал” урлагийн тоглолт, Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс “Ээжтэйгээ дууля” цэнгүүний арга хэмжээ, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр эх үрсийн баярыг тохиолдуулан хүүхдүүдийн дунд Монгол наадгайн тэмцээн, Ном бидний нөхөр дүрийн тоглолт, “Бяцхан мисс-Бяцхан женгельмэн” тэмцээн, ундаг дугуйн уралдааныг зохион явуулсан байна.

Мөн Их-Уул сум Бүх нийтийн мод тарих арга хэмжээг зохион байгуулж нийт 940 ширхэг мод бут сөөг тарьж, иргэн Л.Энхбаярын санаачлагаар “Ногоон суврага” төгөлийг сумын төвийн дээд хэсэгт 0,25 га газрыг хашиж хамгаалалт хийж нарс, улиас нийт 300 ширхэгийг ах дүү нарын хамт тарьсан байна. “Нөхөрлөл хөгжил-2019” өдөрлөгийн арга хэмжээнд ойн мэргэжлийн 2 байгууллага, 9 ойн нөхөрлөлийг хамруулж сургалтын үйл ажиллагаа, “Юмханаар юм хийцгээе-2” үзэсгэлэн худалдаа, гар бөмбөгийн тэмцээн, урлагийн наадам зэргийг зохион байгууллаа.

Төмөрбулаг сумын цэцэрлэгийн эцэг эхчүүдийн дунд “Нэг өдрийг хүүхэддээ зориуля” уриан дор жил бүр уламжлал болгон зохион явагддаг урлаг, спортын тэмцээнд 63 эцэг эх хүүхдийнхээ хамтаар оролцлоо. ЭТК-ын Олон улсын сайн дурын ажилтан Шарлотын санаачилгаар сургуулийн биеийн тамирын гадна талбайд тоглоомын талбайг сургуулийн эрэгтэй ажилтнууд савлуур, турник, саадтай гүйлтийн зам, дүүжин даажин, дугуй дамжих, мотоцикль зэргийг хийж сурагчид чөлөөт цагаа өнгөөрөх газар нэмэгдлээ.

Ханх сумын сургуулийн захиргаанаас санаачлан орос хэлний баярыг анх удаа 5-11-дүгээр ангийн сурагчдын дунд оросоор дуулж, шүлэг, бүжиг, хүүхэлдэйн кинонд дуу оруулах, текст орчуулга болон сурсан мэдсэн зүйлээ багш сурган хүмүүжүүлэгчид ,эцэг эх, олон нийтэд урлагаар дамжуулан тайланчлал зохион байгуулав. Мөн Тункин аймаг Ханх ЕБС-ийн хамтын ажиллагааны өдрүүдийг зохион байгуулав. Тус урлагийн сургуулийнхан ард иргэдэд өөрсдийн бэлтгэсэн тоглолтыг тольлуулж хоёр сургуулийн сурагчдын танилцах үдэшлэг, туршлага судлах ажлыг явуулж, сурагчид орос хэлний ярих чадвараа дээшлүүлсэн үр дүнтэй ажил боллоо.

Хатгал тосгонд Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүдийн 2 дугаар чуулган эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх, эвлэлдэн нэгдэж, хамтран ажиллах, харилцан бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулагдлаа. Нийт 20 сумын 156 төлөөлөгч, аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүлэгч 8, орон нутгийн төлөөлөл 21, зохион байгуулагчид 15, нийт эмэгтэйчүүд оролцож санал бодлоо илэрхийллээ.

Хатгал тосгоны ойн санг гэрээгээр эзэмшдэг нийт 9 нөхөрлөлийн оролцуулан “Нөхөрлөл хөгжил” наадмыг зохион байгуулсан ба тус үйл ажиллагаагаар хаягдал модоор нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд борлуулан дундын санг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдаа зохион байгуулж шалгарсан брэнд бүтээгдэхүүнийг эхний 3 байр эзлүүллээ. Шалгарсан нөхөрлөлүүд аймгийн нэгдсэн “Нөхөрлөл хөгжил” наадамд оролцох эрхийг авлаа.

Мөрөн суманд Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтын хүрээнд “Монгол ногоо” төслийг нэг гудамжийг сонгон “Жишиг гудамж”, болгон хөгжүүлэх зорилгоор өрхүүдэд багаж тоног төхөөрөмж, хүлэмж, үрсэлгээ гардууллаа. Мөн 4-р цэцэрлэгт хүлэмж олголоо.

Мөрөн сумын Засаг даргын санаачлагаар Унадаг дугуйтай Мөрөн аяныг 2014-оноос хойш хэрэгжүүлж эхлүүлсэн билээ. Өмнө нь холын болон ойрын зайн спорт аялалуудыг тогтмол зохион байгуулж байсан бол энэ жил Мөрөн-Эрдэнэбулган чиглэлийн 230км замын дугуйн спорт аялал зохион байгуулж 10 байгууллагын 20 гаруй дугуйчин оролцлоо.